



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 7 сарын 6 өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

Төсвийн хуваарьт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

Нэг. Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 371 дүгээр тушаалын "Монгол Улсын 2016 оны төсвийн орлогын сар, улирлын хуваарь"-ийг 1 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2016 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь"-ийг 2 дугаар хавсралтаар, мөн тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2016 оны төсвийн хөтөлбөр, арга хэмжээний сар, улирлын хуваарь"-ийг 3 дугаар хавсралтаар, мөн тушаалын 12 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2016 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн сар, улирлын хуваарь"-ийг 4 дүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр. Санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу олгохыг Төрийн сангийн газар /С.Наранцогт/-т зөвшөөрсүгэй.

САЙД



Б.БОЛОР

000627

